



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

ГАРЧИГ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХЭД БОЛОН ЦААШИД ТОГТМОЛ ХАНГАХ НӨХЦӨЛ,
ШААРДЛАГА
3. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ
4. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ЭЛСҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ
5. МХБ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДАГАЖ МӨРДӨГДӨХ НИЙТЛЭГ ЗАРЧИМ
6. ГИШҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ДАГАЖ МӨРДӨГДӨХ НИЙТЛЭГ ЗАРЧИМ
7. ГИШҮҮНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС
8. ХАРИУЦЛАГА
9. БУСАД
10. ХАВСРАЛТУУД
 - *Хамтран ажиллах гэрээ*
 - *Гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч компанийн өргөдлийн маягт*
 - *Техник, тоног төхөөрөмжийн шаардлага*

“МХБ” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2014 оны 8 дугаар сарын
13-ны өдрийн 2014/07 тоот тогтоолоор батлав

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

ГАРЧИГ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХЭД БОЛОН ЦААШИД ТОГТМОЛ ХАНГАХ НӨХЦӨЛ,
ШААРДЛАГА
3. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ
4. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ЭЛСҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ
5. МХБ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДАГАЖ МӨРДӨГДӨХ НИЙТЛЭГ ЗАРЧИМ
6. ГИШҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ДАГАЖ МӨРДӨГДӨХ НИЙТЛЭГ ЗАРЧИМ
7. ГИШҮҮНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС
8. ХАРИУЦЛАГА
9. БУСАД
10. ХАВСРАЛТУУД
 - *Хамтран ажиллах гэрээ*
 - *Гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч компанийн өргөдлийн маягт*
 - *Техник, тоног төхөөрөмжийн шаардлага*

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК (цаашид “МХБ ТӨХК” гэх)-д гишүүнээр элсэхээр өргөдөл гаргасан, үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх зохих тусгай зөвшөөрөлтэй этгээдийг гишүүнээр элсүүлэх, гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулна.
- 1.2. Гишүүн нь Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/, МХБ ТӨХК-ийн дүрэм, журам, заавар болон бусад холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- 1.3. МХБ ТӨХК болон гишүүний харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг энэхүү журмын Хавсралт 1-д тусгасан “Хамтран ажиллах гэрээ”-гээр зохицуулна.

ХОЁР. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХЭД БОЛОН ЦААШИД ТОГТМОЛ ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

- 2.1. Гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч болон гишүүнээр элссэн этгээд нь дараах нөхцөл, шаардлагыг хангана:
 - 2.1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь эрх бүхий байгууллагаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг хангасан байх;
 - 2.1.2. СЗХ-ны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.1-д заасан шаардлагад нийцсэн хүний нөөцтэй байх. Гүйцэтгэх захирал нь дээд боловсролтой, санхүү, эдийн засаг, бизнесийн чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан байх, гүйцэтгэх захирал болон мэргэжилтнүүд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос мэргэжлийн эрх олгох журмын дагуу эрхлэх ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан байх;
 - 2.1.3. СЗХ-ны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.1 дэх заалт болон энэхүү журмын Хавсралт 3-т заасан шаардлагуудад тус тус нийцсэн ажлын байр, техник, тоног төхөөрөмжөөр хангагдаж, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байх;
 - 2.1.4. Арилжаа, төлбөр тооцоо, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам баталж, мөрдөх;
 - 2.1.5. Тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулах бизнес төлөвлөгөө боловсруулсан байх;
 - 2.1.6. Энэхүү журмын 7 дугаар зүйлд заасан зохих төлбөр, хөлсийг төлсөн байх;
 - 2.1.7. Өргөдөл гаргагч нь хөрөнгийн зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомжтой бүрэн танилцсан, тэдгээр хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллах,

харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа шударгаар, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхийг тус тус баталсан баталгааг Хавсралт 2-т заасны дагуу ажилтан тус бүрээр гаргуулан ирүүлэх;

- 2.1.8. Нэг ба түүнээс дээш дилер нь МХБ ТӨХК-ийн “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын дагуу арилжаанд оролцох эрх авсан байх;
- 2.1.9. Харилцагчдад холбогдох мэдээлэл хүргэх тогтмол ажилладаг албан ёсны цахим хуудас, суурин утастай байх;
- 2.1.10. Арилжааны төлбөр, тооцоо гүйцэтгэх байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, СЗХ болон “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн холбогдох журмын дагуу барьцаа хөрөнгө болон Төлбөрийн баталгааны санд зохих хэмжээний хөрөнгийг тус тус байршуулсан байх.

ГУРАВ. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ

- 3.1. Гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч нь энэхүү журмын Хавсралт 2-т заасан өргөдлийн маягтыг бөглөж, холбогдох бичиг баримтуудыг хавсарган ирүүлнэ.
- 3.2. Энэ журмын 3.1.-д заасан өргөдлийг холбогдох бичиг баримтын хамт МХБ ТӨХК-д хүргүүлсэн өдрөөс эхлэн өргөдөл гаргагч нь энэхүү уг журмын холбогдох заалтыг мөрдөж ажиллана.
- 3.3. МХБ ТӨХК нь бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан шаардлагуудыг хангаж ирүүлсэн өдрөөс эхлэн ажлын 20 хоногийн дотор гишүүнээр элсүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.4. Шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 3.3-д заасан хугацааг нэг удаа ажлын 14 хоног хүртэл хугацаагаар сунгаж болно.
- 3.5. Өргөдөл гаргагч нь өргөдлийн баримт бичгийг эмхлэн товъёоглож, гүйцэтгэх захирлын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулах ба нотариатаар гэрчлүүлэх шаардлагатай баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нотариатаар гэрчлүүлсэн байна.
- 3.6. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гишүүнээр элсэхдээ холбогдох бичиг баримтуудыг Монгол хэл дээр үйлдэн баталгаажуулж ирүүлнэ.
- 3.7. Шалгалтын явцад буюу гишүүнээр элсүүлэх шийдвэр гарахаас өмнө ирүүлсэн бичиг баримтанд нэмэлт өөрчлөлт орсон бол өргөдөл гаргагч нь энэ тухайгаа ажлын 3 хоногийн дотор МХБ ТӨХК-д мэдэгдэнэ.

ДӨРӨВ. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ЭЛСҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ

- 4.1. Өргөдөл гаргагчийн гишүүнээр элсэх өргөдлийг МХБ ТӨХК-ийн гишүүний үйл ажиллагааг хариуцсан алба хянан шалгаж, шалгалтын тайланг Захирлуудын зөвлөлийн хурал (цаашид “ЗЗХ” гэх)-д танилцуулах ба ЗЗХ-ын санал, дүгнэлтийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) гишүүнээр элсүүлэх эсэх шийдвэрийг гаргана.
- 4.2. Өргөдөл гаргагч нь дараах нөхцөл, шаардлагуудыг хангасан тохиолдолд гишүүнээр элсүүлнэ. Үүнд:
 - 4.2.1. Энэхүү журмын 2.1-т заасан шаардлагуудыг хангасан;
 - 4.2.2. Энэхүү журмын Хавсралт 2-д тусгасан бичиг баримтуудыг бүрэн ирүүлсэн;

- 4.2.3. СЗХ-ноос зохих тусгай зөвшөөрөл авсан.
- 4.3. Өргөдөл гаргагч нь энэхүү журмын 2.1.1-2.1.7 болон 4.2.2 дахь заалтуудад заасан шаардлагуудыг хангасан тохиолдолд МХБ ТӨХК нь гишүүнээр элсүүлэхэд татгалзах зүйлгүй тухай дүгнэлт гарган СЗХ-нд хүргүүлнэ.
- 4.4. Өргөдөл гаргагч нь журмын 2.1.8-2.1.10 болон 4.2.3 дахь заалтанд тусгасан шаардлагыг хангасан тохиолдолд ТУЗ гишүүнээр элсүүлэх эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ.
- 4.5. МХБ ТӨХК нь дор дурдсан үндэслэл бүхий нөхцөл байдал илэрвэл гишүүнээр элсэх өргөдлийг буцааж, гишүүнээр элсүүлэхээс татгалзаж болно:
- 4.5.1. Бичиг баримтын бүрдэл дутуу, зөрчилтэй, худал, төөрөгдүүлсэн, алдаатай эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл агуулсан, МХБ ТӨХК-аас өргөдөлтэй холбогдуулан шаардсан мэдээллийг бүрэн ирүүлээгүй;
- 4.5.2. Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөл, шаардлагуудыг хангаагүй;
- 4.5.3. Өргөдөл гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсвэл толгой компани нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан, энэ тухай өргөдөл гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн;
- 4.5.4. Өргөдөл гаргагч, түүний нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өр төлбөртэй, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчиж байсан, сүүлийн 5 жилийн хугацаанд аливаа зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж, гишүүний эрх нь цуцлагдсан үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан;
- 4.5.5. Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл толгой компани нь эдийн засгийн гэмт хэрэгт холбогдон буруутай нь тогтоогдсон, эсхүл сэжиглэгдэн шалгагдаж байгаа;
- 4.5.6. Гишүүний эрхийг цуцалсан эсхүл гишүүнээр элсүүлэхээс татгалзсан компани, түүний хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтнуудаас дахин гишүүнээр элсэх тухай өргөдлийг 1 жилийн дотор МХБ ТӨХК-д гаргасан;
- 4.5.7. Өргөдөл гаргагч гишүүнээр элсэж, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх нөхцөлийн эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компанийн үйл ажиллагаатай харшилж, сонирхлын зөрчил үүсгэнэ гэж үзсэн.
- 4.6. МХБ ТӨХК нь энэхүү журмын 4.5-д зааснаар гишүүнээр элсүүлэх өргөдлийг буцаахдаа холбогдох шийдвэрийг үндэслэл бүхий тайлбарын хамт өргөдөл гаргагч этгээдэд бичгээр хүргүүлнэ.

ТАВ.МХБ ТӨХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДАГАЖ МӨРДӨГДӨХ НИЙТЛЭГ ЗАРЧИМ

- 5.1. МХБ ТӨХК нь үйл ажиллагаандаа дараах нийтлэг зарчмыг баримталж ажиллана:
- 5.1.1. МХБ ТӨХК нь гишүүнээр элсэх өргөдөл гаргасан этгээдийн өргөдлийг хянан шийдвэрлэх, гишүүнийг арилжаанд оролцоход шаардлагатай үйлчилгээг үзүүлэх, гишүүнд хяналт тавих, хариуцлага ногдуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ нээлттэй, ижил төстэй үйл ажиллагаа эрхлэх компаниудад ижил тэгш хандах буюу үл ялгаварлах зарчмыг суурь болгож ажиллах;

- 5.1.2. Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр гишүүн компаниудтай хамтран ажиллах;
- 5.1.3. Энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ шударгаар, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх;
- 5.1.4. Үнэт цаасны арилжааг тогтоосон хугацаанд тасралтгүй, ил тод, алдаагүй, шударгаар зохион байгуулж, арилжаатай холбоотой болон хуулинд заасан мэдээллийг түгээх;
- 5.1.5. Гишүүний үйл ажиллагаатай холбоотой асуудлаар СЗХ болон эрх бүхий байгууллагаас ирүүлсэн аливаа мэдээллийг гишүүнд шуурхай хүргүүлэх.

ЗУРГАА. ГИШҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДАГАЖ МӨРДӨГДӨХ НИЙТЛЭГ ЗАРЧИМ

- 6.1. Гишүүн нь үйл ажиллагаандаа дараах нийтлэг зарчмыг баримталж ажиллана:
 - 6.1.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, СЗХ-ны журам, зааврууд, энэхүү журам, МХБ ТӨХК-ийн “Гишүүдийн ажилтны ёс зүйн дүрэм” болон МХБ ТӨХК-аас баталсан бусад холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах;
 - 6.1.2. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн нэр хүндийг унагаах аливаа үйлдэл хийхгүй байх, харилцагч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах;
 - 6.1.3. Гишүүн нь өөрийн ажилтнууд, хамтран ажиллах этгээдүүдийн үйл ажиллагаанаас үүсэх үр дагаврыг МХБ ТӨХК-ийн өмнө хариуцах;
 - 6.1.4. Арилжааны системийн нууцлалыг хангаж, системийг шударгаар, зүй зохистойгоор ашиглаж, системд нэвтрэх эрхийг бусдад дамжуулахгүй байх, системд техникийн аливаа асуудал гарсан тохиолдолд МХБ ТӨХК-д нэн даруй мэдэгдэж, МХБ ТӨХК-ийн зааврын дагуу ажиллах;
 - 6.1.5. Гишүүн нь хийгдсэн хэлцэл болон холбогдох бусад үйл ажиллагааг хянах дотоод хяналтын зохих тогтолцоог бүрдүүлж ажиллах ба арилжаа явагдах, хийгдсэн хэлцлийн төлбөр тооцоо хугацаандаа гүйцэтгэгдэхэд саад учруулах аливаа нөхцөл байдал үүсгэхгүй байх;
 - 6.1.6. Гишүүнчлэлийн аливаа төлбөр, үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд нь төлж барагдуулах;
 - 6.1.7. Гишүүн нь энэхүү журмын 2.1-т заасан шаардлагыг хангахад гарсан аливаа өөрчлөлтүүдтэй холбоотой мэдээлэл болон санхүүгийн тайлан зэрэг гэрээнд заасан мэдээллийг МХБ ТӨХК-д тогтоосон хугацаанд ирүүлэх.

ДОЛОО. ГИШҮҮНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

- 7.1. Гишүүн нь МХБ ТӨХК-д дараах үйлчилгээний хөлсийг төлнө:
 - 7.1.1. Гишүүнээр элсэх өргөдлийг хянан шийдвэрлэх үйлчилгээний хөлс – 500,000 төгрөг байх ба өргөдөл гаргах үедээ буцаан олгогдохгүй нөхцөлтэйгөөр төлнө.
 - 7.1.2. Гишүүнчлэлийн элсэлтийн хөлс – 15,000,000 төгрөг байх ба гишүүнээр элсүүлэх шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор төлнө.

- 7.1.3. Гишүүнчлэлийн жилийн хөлс- 2,500,000 төгрөг байх ба хөлсийг 4 хувааж, улирал бүрийн эхний 10 хоногт багтаан төлнө.
- 7.1.4. Арилжааны системд нэвтрэх эрх ашигласны хөлс –нэвтрэх эрх тус бүр нь улирлын 195,000 төгрөг байх ба улирлын эхний 10 хоногт төлнө.
- 7.2. Гишүүн компани нь МХБ ТӨХК дээр хийгдсэн тухайн жилийн нийт арилжааны үнийн дүнгийн 10-аас дээш хувьтай тэнцэх гүйлгээг дангаар хийсэн бол дараа жилийн гишүүнчлэлийн жилийн хөлсийг 50 хүртэлх хувиар хөнгөлж болно.
- 7.3. Шинээр элссэн гишүүн нь түүнийг гишүүнээр элсүүлэх тухай шийдвэр гарсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд журмын 7.1.3-т заасан хөлснөөс чөлөөлөгдөнө.
- 7.4. Гишүүний эрхийг түдгэлзүүлсэн нь гишүүнийг жилийн хөлс төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 7.5. Гишүүний эрхийг цуцалсан тохиолдолд гишүүнчлэлийн элсэлтийн болон жилийн хөлсийг буцаан олгохгүй.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

- 8.1. МХБ ТӨХК нь гишүүний хууль тогтоомж, журам, заавар, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавих ба гишүүний үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлын төрлөөс шалтгаалан гишүүнд дараах арга хэмжээг авна:
 - 8.1.1 Сануулах арга хэмжээ авах.
 - 8.1.2 Хамтран ажиллах гэрээний дагуу торгууль, алданги тооцож төлүүлэх. Хэрэв нэг жилийн хугацаанд гишүүн нь ижил төрлийн зөрчил гаргаж, түүнд журмын 8.1.1-т заасан арга хэмжээ авагдаж байсан бол мөн энэхүү арга хэмжээг ноогдуулна.
 - 8.1.3 Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах. Дараах тохиолдлуудад гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлана:
 - 8.1.3.1 Журам, дүрэм, заавар болон Хамтран ажиллах гэрээний дагуу үүргээ биелүүлээгүй;
 - 8.1.3.2 СЗХ болон СЗХ-ны Улсын байцаагчийн шийдвэрээр;
 - 8.1.3.3 МХБ ТӨХК-ийн “Хяналт шалгалтын журам”-ын 14.2-т заасан зөрчлийг гаргасан нь тогтоогдож, МХБ ТӨХК-ийн хяналт шалгалт хариуцсан албанаас гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах тухай санал, дүгнэлт гаргасан;
 - 8.1.3.4 Энэхүү журмын 7 дугаар зүйл болон Хамтран ажиллах гэрээнд заасан аливаа төлбөр, хөлсийг хугацаанд нь төлж барагдуулалгүй 30 хоног болсон;
 - 8.1.3.5 Арилжааны төлбөр гүйцэтгэх үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тухай төлбөр, тооцоо гүйцэтгэх байгууллагаас мэдэгдсэн;
 - 8.1.3.6 Арилжааны төлбөр, тооцоо гүйцэтгэх байгууллагатай хамтран ажиллах гэрээ цуцлагдсан эсхүл барьцаа хөрөнгө, Төлбөрийн баталгааны санд зохих хэмжээний хөрөнгийг тус тус байршуулаагүй;
 - 8.1.3.7 Гишүүний ажилтан нь МХБ ТӨХК-ийн “Гишүүний ажилтны ёс зүйн дүрэм”-ийг удаа дараа зөрчсөн;
 - 8.1.3.8 Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.

- 8.1.4. Гишүүний эрхийг түдгэлзүүлэх. Дараах тохиолдлуудад гишүүний эрхийг түдгэлзүүлнэ:
- 8.1.4.1. Олон нийтийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаа, хуурамч мэдээлэл тараасан, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал үүсгэсэн;
 - 8.1.4.2. МХБ ТӨХК-ийн “Хяналт шалгалтын журам”-ын дагуу МХБ ТӨХК-ийн хяналт шалгалт хариуцсан албанаас гишүүний эрхийг түдгэлзүүлэх тухай санал, дүгнэлт гаргасан;
 - 8.1.4.3. Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарласан зөрчлийг арилгалгүй 3 сар болсон;
 - 8.1.4.4. Энэхүү журмын нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл хангахгүй болсон;
 - 8.1.4.5. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй;
 - 8.1.4.6. Брокер, дилерийн үйл ажиллагаа явуулалгүй 6 ба түүнээс дээш сар болсон;
 - 8.1.4.7. Хууль, дүрэм, журам, гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актанд заасан бусад үндэслэл.
 - 8.1.4.8. СЗХ-ноос гишүүний брокер, дилерийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон боловч МХБ ТӨХК-аас хөрөнгө оруулагчид, зах зээлд оролцогч бусад этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах үүднээс тухайн гишүүний эрхийг түдгэлзүүлж, эрх цуцлах хугацааг 3 хүртэл сараар хойшлуулах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч болно.
- 8.1.5. Гишүүний эрхийг цуцлах. Дараах тохиолдлуудад гишүүний эрхийг цуцална:
- 8.1.5.1 Гишүүн өөрөө хүсэлт гаргасан. Энэ тохиолдолд гишүүн нь МХБ ТӨХК-иас тавих нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан байна;
 - 8.1.5.2 СЗХ-ноос үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон;
 - 8.1.5.3 Гишүүний төлбөрийн чадвар нь алдагдсан, эсхүл төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон, түүнийг татан буулгах ажиллагаа эхэлсэн, дампуурлын хэрэг гүйцэтгэгч буюу эрх хүлээн авагч томилогдсон зэрэг тохиолдолд СЗХ, шүүх, хяналтын байгууллагын шийдвэрийн дагуу;
 - 8.1.5.4 МХБ ТӨХК-ийн “Хяналт шалгалтын журам”-ын дагуу МХБ ТӨХК-ийн хяналт шалгалт хариуцсан албанаас гишүүний эрхийг цуцлах тухай санал, дүгнэлт гаргасан;
 - 8.1.5.5 Гишүүний эрхийг түдгэлзүүлснээс хойш 6 сарын хугацаанд эрх сэргээлгэх талаар арга хэмжээ аваагүй;
 - 8.1.5.6 Энэхүү журмын 7 дугаар зүйл болон хамтран ажиллах гэрээнд заасан аливаа төлбөр, хураамж, хөлсийг хугацаанд нь төлж барагдуулалгүй 3 сар болсон;
 - 8.1.5.7 МХБ ТӨХК-ийн үнэт цаасны арилжаа, гишүүнчлэл, хяналтын журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг удаа дараа ноцтойгоор зөрчсөн;
 - 8.1.5.8 МХБ ТӨХК болон дотоодын хөрөнгийн зах зээлийн нэр хүндэд ноцтойгоор харшлах үйл ажиллагаа, үйлдэл хийсэн нь тогтоогдсон;
 - 8.1.5.9 Гишүүнээр элсэхдээ хуурамч баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

8.1.5.10 Хууль, дүрэм, журам, гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актан
даасан бусад үндэслэл.

- 8.2. Гишүүний эрхийг сэргээх. Дараах тохиолдолд гишүүний эрхийг сэргээнэ:
 - 8.2.1. Гишүүн гаргасан зөрчлөө арилгасан тухайгаа мэдэгдсэн, эсхүл МХБ ТӨХК-иас зөрчил арилсан гэж тогтоосон;
 - 8.2.2. СЗХ-ноос гишүүний тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
 - 8.2.3. МХБ ТӨХК-ийн ТУЗ, эсхүл зохицуулах эрх бүхий байгууллага, шүүх хяналтын байгууллагаас гишүүнд авсан арга хэмжээг үндэслэлгүй гэж үзсэн;
 - 8.2.4. Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.
- 8.3. Энэхүү журмын 8.1.1-8.1.3-т заасан хариуцлагын арга хэмжээг хариуцсан албаны саналыг үндэслэн Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.
- 8.4. Энэхүү журмын 8.1.4, 8.1.5-д заасан хариуцлагын арга хэмжээг ЗЗХ-ын саналыг үндэслэн Гүйцэтгэх захирлын танилцуулснаар ТУЗ шийдвэрлэнэ.

ЕС. БУСАД

- 9.1 Энэхүү журмын 8.1.3, 8.1.4-д заасан арга хэмжээ авагдсан тохиолдолд МХБ ТӨХК нь гишүүний арилжааны системд оруулсан нээлттэй захиалгуудыг устгах арга хэмжээ авч болно.
- 9.2. МХБ ТӨХК нь гишүүний эрхийг түдгэлзүүлсэн, цуцалсан тохиолдолд СЗХ, төлбөр, тооцоо гүйцэтгэх байгууллага болон гишүүнд холбогдох шийдвэрийг нэн даруй мэдэгдэнэ.
- 9.3. МХБ ТӨХК нь сануулах болон 100,000 төгрөгөөс бага хэмжээний торгууль төлүүлэх арга хэмжээ авагдсанаас бусад арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлнэ. Тухайн зөрчлөөс өмнөх нэг жилийн хугацаанд МХБ ТӨХК-аас нийтэд мэдээлэлгүйгээр тухайн гишүүнд гурван удаа арга хэмжээ авч байсан тохиолдолд арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлнэ.
- 9.4. Гишүүн нь энэхүү журмын 8 дугаар зүйлд заасан арга хэмжээг авах тухай Гүйцэтгэх захирлын шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор МХБ ТӨХК-ийн ТУЗ-д, ТУЗ-ийн шийдвэрийг эс зөвшөөрвөл мөн хугацаанд СЗХ-нд хандан шийдвэрлүүлж болно.
- 9.5. Гишүүний эрхийг түдгэлзүүлэх, цуцлах нь тухайн гишүүний МХБ ТӨХК болон бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийг дуусгавар болгох, уг гэрээ хэлцлээр хүлээсэн үүрэг, учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 9.6. Гишүүний эрх цуцлагдсан тохиолдолд тухайн компаниас гишүүнээр элсэх тухай өргөдлийг 1 жилийн хугацаанд хүлээн авахгүй.
- 9.7. Гишүүний эрх цуцлагдсан тохиолдолд гишүүн нь харилцагчаас өгсөн захиалгын бүртгэл, захиалгын гэрээ, санхүүгийн тайлан баланс, арилжааны хэлцэл, арилжааны товчоо зэрэг баримтуудыг СЗХ ба МХБ ТӨХК-ийн шийдвэрт заасан хугацаанд МХБ ТӨХК-д хүлээлгэн өгнө.
- 9.8. Энэхүү журмыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тэдгээрийн хүчин төгөлдөр болох хугацаа, дагаж мөрдөх журмын талаарх МХБ ТӨХК-ийн ТУЗ-ийн шийдвэр нь СЗХ батламжилснаар хүчин төгөлдөр болно.

Батлав. “МХБ ТӨХК”ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирал

Батлав.“.....” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

.....

.....

ХАМТРАН АЖИЛЛАХГЭРЭЭ

201... оны ... сарын
... -ны өдөр

№...

Улаанбаатар хот

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү гэрээг нэг талаас “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК, түүнийг төлөөлөн
..... /цаашид “МХБ ТӨХК” гэх/, нөгөө талаас МХБ ТӨХК-ийн
гишүүн “.....” ХХК /цаашид “гишүүн” гэх/, /хамтад нь “талууд”
гэх/ нар хамтран ажиллахаар Монгол Улсын Иргэний хуулийн 476-482 дугаар зүйлд
заасны дагуу харилцан тохиролцож байгуулав.

- 1.1 Талууд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон түүний гишүүн компанийн эрх, үүргийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчид болон харилцагчдад түргэн шуурхай үйлчлэх, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, холбогдох тайлан, мэдээ судалгааг солилцох, зах зээлийн холбогдолтой судалгаа сурталчилгааны ажил дээр хамтран ажиллана.
- 1.2 Талууд хамтын ажиллагаандаа Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/, МХБ ТӨХК-аас баталсан журам, заавар болон энэхүү гэрээг дагаж мөрдөнө.
- 1.3 Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд, эсхүл талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 1.4 Талууд хамтран ажиллахдаа бизнесийн болон ажил хэргийн нэр хүндийг гуравдагч этгээдийн өмнө харилцан хамгаалж, хууль ёсны эрх ашгийг хүндэтгэнэ.

Хоёр. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 МХБ ТӨХК-ийн эрх

- 2.1.1 “Гишүүнчлэлийн журам” болон энэхүү гэрээнд заасан үйлчилгээний хөлс болон холбогдох бусад төлбөрийг цаг тухайд нь төлүүлэх, тогтоосон хугацаанд төлөөгүй нөхцөлд “Гишүүнчлэлийн журам”-д заасны дагуу хариуцлага ногдуулах;

- 2.1.2 Гишүүний үйл ажиллагаанд хяналт тавьж, өргөдөл гомдлын дагуу болон журам заавар, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор шалгалт хийж, МХБ ТӨХК-ийн “Хяналт шалгалтын журам”, “Иргэн, албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх заавар” болон бусад холбогдох журам, гэрээнд заасны дагуу хариуцлага ногдуулах;
- 2.1.3 Гишүүний санхүүгийн тайлан мэдээ, удирдлага, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүний талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх;
- 2.1.4 Гишүүн компаниудын хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүрэг болон МХБ ТӨХК-аас гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах;
- 2.1.5 Гишүүн нь баримт материал хуурамчаар бүрдүүлсэн байж болзошгүй тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгдэх, шалгуулах;
- 2.1.6 Гишүүний гаргасан зөрчил нь хөрөнгө оруулагч, харилцагчдад их хэмжээгээр хохирол учруулсан бөгөөд хохирлоо барагдуулаагүй, мөн гэмт хэргийн шинжтэй бол холбогдох материалыг бүрдүүлэн эрх бүхий байгууллагад шилжүүлэх.

2.2 МХБ ТӨХК-ийн үүрэг

- 2.2.1 Өдөр тутмын арилжааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ ТӨХК-ийн журмын дагуу зохион байгуулах, арилжааны программын хэвийн ажиллагааг хангах;
- 2.2.2 Гишүүний хүсэлтийн дагуу түүний техник хангамж, программ хангамжийг МХБ ТӨХК-ийн сүлжээнд анх холбоход шаардлагатай техникийн болон үйл ажиллагааны туслалцааг төлбөргүйгээр үзүүлэх, арилжааны системийг ашиглах заавар, зөвлөгөө өгөх;
- 2.2.3 Шаардлагатай мэдээ, материалыг цаг тухайд нь гишүүнд гаргаж өгөх;
- 2.2.4 Гишүүний ажилтнуудад мэргэжлийн нэгдсэн сургалт зохион байгуулах, арилжаанд оролцох эрх олгох шалгалт авах;
- 2.2.5 МХБ ТӨХК-ийн арилжааны системийн хэвийн ажиллагааг хангаж, мэдээллийн нууцлалыг хадгалах;
- 2.2.6 Харилцагч болон гишүүнээс ирүүлсэн санал, хүсэлтэд холбогдох эрх бүхий албан тушаалтан нь утсаар болон бусад арга, хэрэгслээр хариу өгөх;
- 2.2.7 Гишүүдийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг шударга дүгнэх, дүнг мэдээлэх;
- 2.2.8 Гишүүнийг арилжаанд оролцох, мэдээлэл авах ижил нөхцөлөөр хангах.

2.3 Гишүүний эрх

- 2.3.1 Үнэт цаасны арилжаа, үнэ ханшийн болон зах зээлийн холбогдолтой нийтэд тараагдах мэдээ, мэдээллийг гаргуулан авах;
- 2.3.2 Үнэт цаасны зах зээл, хөрөнгийн бирж, гишүүдийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал гаргах, МХБ ТӨХК-тай хамтран ажиллах;
- 2.3.3 МХБ ТӨХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах;
- 2.3.4 МХБ ТӨХК-д санал хүсэлт гаргах, тогтоосон хугацаанд үндэслэл бүхий хариу авах, шийдвэрлэх асуудлаар харилцан зөвшилцөх;
- 2.3.5 МХБ ТӨХК-ийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд СЗХ-нд гомдол гаргах.

2.4 Гишүүний үүрэг

- 2.4.1 Арилжааны системд МХБ ТӨХК-ийн “Гишүүнчлэлийн журам”-д заасан шаардлага хангасан техник хэрэгсэл ашиглах ба Арилжааны системд нэвтрэх код, программ хангамжийн тохиргоо, түүний нууцлал, хамгаалалтыг хангаж, зориулалтын дагуу ашиглах, үүнтэй холбоотойгоор гарах аливаа зардлыг хариуцах;
- 2.4.2 Гишүүний үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажилтнууд нь МХБ ТӨХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох, аттестатчилах шалгалтанд тухай бүр хамрагдаж, эрх авах;
- 2.4.3 “Гишүүнчлэлийн журам”-д заасны дагуу гишүүнчлэлийн жилийн хөлсийг 4 хувааж, улирал бүрийн эхний 10 хоногт багтаан төлөх, арилжааны системд нэвтрэх эрхийн төлбөрийг улирал бүрийн эхний 10 хоногийн дотор, арилжааны танхимаас МХБ ТӨХК-ийн телефон утас ашиглан арилжаа хийсэн тохиолдолд утасны төлбөрийг дараа сарын 20-ны дотор, торгууль, алдангийг тогтоосон хугацаанд багтаан төлөх;
- 2.4.4 Гишүүний ажлын байрны байршил, хаяг тодорхой байх, олон нийтэд тодорхой бус нөхцөлд ойролцоо гарц гармын дагуу тэмдэг тавих, шилжилт хөдөлгөөнийг тухай бүр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, харилцагчдыг хүлээн авах цагийн хуваарь гарган тогтмол мөрдөж ажиллах;
- 2.4.5 Гишүүн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, үндсэн үйл ажиллагаа эрхэлж буй ажилтнууд, хаяг байршил, холбоо барих мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор МХБ ТӨХК-д мэдэгдэх;
- 2.4.6 Ирэх жилд хийхээр төлөвлөж буй арилжааны үнийн дүнг нарийвчлан боловсруулж ирүүлэх, биелэлтийг хангаж ажиллах;
- 2.4.7 МХБ ТӨХК-ийн “Гишүүн компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар”-т тусгасан мэдээлэл болон гэрээнд заасан бусад мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэх;
- 2.4.8 Холбогдох журмын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, түүний үнэн зөвийг хариуцах, харилцагчийн утсаар өгсөн захиалгыг дуу хоолойны болон дүрст бичлэгээр баталгаажуулж, бичлэгийг компьютерийн санамжид файл хэлбэрээр хадгалах, цахим хэлбэрээр ирүүлсэн захиалгыг захиалгын гэрээнд хавсаргах, цахим хэлбэрээр захиалга авах тусгай програм хэрэглэх, хяналт шалгалтын ажиллагааны явцад шаардлагатай тохиолдолд анхан шатны баримт, холбогдох бусад баримт мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэх;
- 2.4.9 Жилийн эцсийн болон хагас жилийн санхүүгийн тайлан, тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд заасан стандартын дагуу гаргаж, жилийн тайланг аудитын дүгнэлтийн хамт дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор, хагас жилийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор МХБ ТӨХК-д тус тус ирүүлэх;

Гурав. ХАРИЛЦАА ХОЛБОО

- 3.1 МХБ ТӨХК нь гишүүнд мэдээллийг МХБ ТӨХК-ийн цахим хуудас эсвэл цахим шуудангаар болон бичгээр хүргүүлж болно.
- 3.2 Гишүүн нь МХБ ТӨХК-д хүргүүлэх аливаа мэдээллийг бичгээр хүргүүлнэ.

- 3.3 Энэхүү гэрээний 3.1-д заасны дагуу МХБ ТӨХК-аас мэдээллийг шуудангаар /албан бичгээр болон цахим хэлбэрээр/ илгээсэн тохиолдолд ажлын 3 хоногт, цахим хуудаст нийтэлсэн тохиолдолд тухайн өдөр гишүүнийг танилцсанд тооцно.

Дөрөв. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 4.1 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал хариуцан барагдуулна.
- 4.2 Гишүүн нь гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд гишүүнд дараах шат дараалсан арга хэмжээг авч, үүргийн биелэлтийг хангуулна.
- 4.2.1. Бичгээр албан шаардлага хүргүүлэх /сануулах арга хэмжээнд тооцогдоно/;
- 4.2.2. МХБ ТӨХК нь гишүүнээс дараах төрлийн торгуулийг Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн дагуу нэхэмжлэх эрхтэй:
- а/ Үнэт цаасны арилжаатай холбоотой анхан шатны баримт дугуу, буруу хөтөлсөн – 50,000 төгрөг /зөрчлийг давтан гаргасан тохиолдолд 100,000 төгрөг/;
- б/ Энэхүү гэрээнд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй– 100,000 төгрөг /давтан гаргасан тохиолдолд 200,000 төгрөг/;
- г/ Харилцагчийн захиалгыг арилжааны программд оруулахад анхаарал болгоомжгүйн улмаас удаа дараа алдаа гаргасан, арилжааны дэгийг удаа дараа зөрчсөн, арилжааны программыг зохисгүйгээр ашигласан, нууцлалыг алдагдуулсан болон гэрээний 2.4.8 дахь заалтыг зөрчсөн- 500,000 төгрөг /зөрчлийг давтан гаргасан тохиолдолд 1,000,000 төгрөг/;
- д/МХБ ТӨХК-ийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд - 500,000 төгрөг;
- е/ Харилцагчтай гэрээ байгуулаагүй, харилцагчийн мөнгөн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлаагүй –500,000 төгрөг /зөрчлийг давтан гаргасан тохиолдолд 1,000,000/;
- 4.2.3. Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах;
- 4.2.4. Гишүүний эрхийг түдгэлзүүлэх;
- 4.2.5. Гишүүний эрхийг цуцлах.
- 4.3. Гишүүн нь ногдуулсан торгуулийг ажлын 5 хоногт багтаан төлөөгүй тохиолдолд түүнд гэрээний 4.2.3, 4.2.4-т заасан хариуцлагыг хүлээлгэж болно.
- 4.4. Талууд төлбөрийн үүрэг /хөлс, төлбөр/-ээ биелүүлээгүй нөхцөлд Иргэний хуулийн 232.6-д заасныг үндэслэн хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги төлнө.
- 4.5. Гишүүн нь гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээний 4.2-д заасан хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран буруутай этгээдийн гишүүний эрхийг үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, цуцлах зэрэг арга хэмжээ авч болно.

Тав. БУСАД ЗҮЙЛ

- 5.1 Цахилгаан, сүлжээний дэд бүтэц (үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хамаарах) болон МХБ ТӨХК-ийн үйл ажиллагаанаас үл хамаарах бусад гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөлийн улмаас үүссэн аливаа хохирлыг МХБ ТӨХК хариуцахгүй.
- 5.2 Энэхүү гэрээ нь гишүүний эрх цуцлагдсан ба брокер дилерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, эсхүл хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр цуцлагдана.
- 5.3 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба 30 хоногийн дотор тодорхой шийдвэрт хүрч чадаагүй тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

МХБ ТӨХК-ийг төлөөлөн:

“.....” ХХК-ийг
төлөөлөн:

.....

.....

/...../

/...../



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”ТӨХК-ИЙН ГИШҮҮНЭЭР
ЭЛСЭХЭЭР ӨРГӨДӨЛГАРГАГЧ КОМПАНИЙН ӨРГӨДЛИЙН
МАЯГТ**

НЭГ. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

1 Компанийн ерөнхий мэдээлэл				
1.1	Компанийн нэр			
1.2	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар			
1.3	Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан огноо			
1.4	Регистрийн дугаар			
1.5	Компанийн харьяалал			
1.6	Хувьцаат капиталын дүн			
1.7	СЗХ-ны тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөл авсан огноо	Тогтоолын дугаар	
	Брокер			
	Дилер			
	Андеррайтер			
	Хөрөнгө оруулалтын зөвлөх			
	Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ			
2 Үйлчилгээний нөхцөл				
2.1	Данс нээх хураамж			
2.2	Арилжааны шимтгэл	Хувьцаа	ЗГ-ийн бонд	Компанийн бонд
2.3	Харилцагч банкны	<i>Нэр</i>		<i>Дансны дугаар</i>
2.4	Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкнынэр			
2.5	Ажиллах цагийн хуваарь			
3 Хаяг, байршил				
3.1	Ажлын байрны талаарх мэдээлэл	<input type="checkbox"/> Өөрийн		<input type="checkbox"/> Түрээс
3.2	Байршил	Төв:		
		Салбар:.....		
3.3	Вэб сайт			
3.4	И-мэйл хаяг			
3.5	Ажлын утас, факс			
4 Үүсгэн байгуулагч				
№	Овог, нэр	Оруулсан хөрөнгийн		Ажил эрхлэлтийн байдал
		Үнийн дүн	Хувь	

5	<i>Төлөөлөн удирдах зөвлөл</i>				
№	Овог, нэр	Албан тушаал	Ажил эрхлэлт		
1					
2					
3					
4					
5					
6					
6	<i>Санхүүгийн үзүүлэлт/..... оны сарын –ны байдлаар/</i>				
№	Үзүүлэлт	Актив	Пассив		
	Нийт хөрөнгө				
1	Эргэлтийн хөрөнгө				
	Эргэлтийн бус хөрөнгө				
2	Өр төлбөр, Эзэмшигчийн өмчийн дүн				
	Өр төлбөр				
	Эзэмшигчийн өмч				
3	Тэнцэл				
4	Аудит хийсэн компани	Нэр:	Хаяг:		
7	<i>Санхүүгийн төлөвлөгөө</i>				
№	Үзүүлэлт	20... он	20... он	20... он	
1	Нийт гүйлгээний дүн				
	Хувьцаа				
	Засгийн газрын бонд				
	Компанийн бонд				
2	Нийт орлого				
	1.Брокерийн үйл ажиллагаанаас				
	2. Дилерийн үйл ажиллагаанаас				
	3.Андеррайтерийн үйл ажиллагаанаас				
4. Бусад орлого					
3	Нийт зардал				
4	Цэвэр ашиг				
8	<i>Ажиллагсдын мэдээлэл /салбарыг оролцуулна/</i>				
№	Ажилтнуудын овог, нэр	Албан тушаал	Ажилд орсон огноо	ҮЦЗЗ-д мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх	МХБ ТӨХК-ийн үнэмлэхний дугаар


				үнэмлэхний дугаар	
1					
2					
3					
4					
5					
6					
9	Бусад мэдээлэл			Тийм	Үгүй
1	Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл толгой компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчиж байсан, сүүлийн 5 жилийн хугацаанд зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж, гишүүний эрх нь цуцлагдсан үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан эсэх				
2	Өргөдөл гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компани дампуурсан, төлбөрийн чадваргүйд тооцогдож байсан эсэх				
3	Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл толгой компани нь эдийн засгийн гэмт хэрэгт холбогдон буруутай нь тогтоогдсон эсхүл сэжиглэгдэн шалгагдаж байгаа эсэх				
<i>*“Тийм” хариултын тайлбарыг хавсаргана уу.</i>					
10	Бүрдүүлэх материалын жагсаалт				
Дараах баримт бичгийг энэхүү өргөдлийн маягтынхамт ирүүлнэ. Үүнд:					
<input type="checkbox"/> 1. МХБ ТӨХК-д гишүүнээр элсэхийг хүссэн албан бичиг;					
<input type="checkbox"/> 2. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх байгууллага байгуулах тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр;					
<input type="checkbox"/> 3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;					
<input type="checkbox"/> 4. Компанийн дүрмийн баталгаажсан хуулбар;					
<input type="checkbox"/> 5. Бизнес төлөвлөгөө /3-5 жил/;					
<input type="checkbox"/> 6. Санхүүгийн баталгаажсан тайлан баланс;					
<input type="checkbox"/> 7. Дансны мөнгөн хөрөнгийн тодорхойлолт, бусад баталгаа /сүүлийн 3 сараас доошгүй хугацааны дансны хуулга/;					
<input type="checkbox"/> 8. Харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай албан бичиг;					
<input type="checkbox"/> 9. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, албан тушаалтнуудын татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт;					
<input type="checkbox"/> 10. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, албан тушаалтнуудын өр төлбөртэй эсэх талаарх ШШГЕГ-ын тодорхойлолт;					
<input type="checkbox"/> 11. Албан тушаалтны мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхний хуулбар, их, дээд сургуулийн дипломын хуулбар, “Гишүүнчлэлийн журам”-ын хавсралтаар баталсан дэлгэрэнгүй анкет, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээний хуулбар;					
<input type="checkbox"/> 12. Тоног төхөөрөмж, эд хөрөнгийн жагсаалт, журамд заасан шаардлага хангасан эсэхийг тодорхойлох баримт;					
<input type="checkbox"/> 13. Түрээсийн гэрээ эсвэл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ;					
<input type="checkbox"/> 14. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны журмын дагуу дотооддоо мөрдөхөөр гаргасан журам, зааврууд;					
<input type="checkbox"/> 15. Арилжааны төлбөр, тооцоо гүйцэтгэх байгууллагатай байгуулсан гэрээний хуулбар;					
<input type="checkbox"/> 16. Өргөдлийн хураамж төлсөн баримт;					

17. Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, СЗХ-ны тогтоолын хуулбар.

*Албан ёсны баримт бичгийг заавал нотариатаар баталгаажуулах шаардлагатай.
Энэхүү жагсаалтын 15-17 дугаарт заасан баримт бичгийг
СЗХ-ноос зохих тусгай зөвшөөрөл авсны дараа ирүүлнэ.*

11 | Батламж

Монголын хөрөнгийн биржийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч “.....” компани нь Монголын хөрөнгийн биржид ирүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ба цаашид Монгол Улсын хууль тогтоомж, үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох журам, заавар, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.



Захирал

/ Гарын үсэг/

20... оны ... сарын ... -ний өдөр

**ХОЁР. А)ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ИРГЭН,
АЛБАН ТУШААЛТНЫМЭДЭЭЛЭЛ**

1 Ерөнхий мэдээлэл								
1.1	Овог	<div style="border: 1px solid black; padding: 10px; width: fit-content; margin: auto;"> Цээж зураг 3x4 см </div>						
1.2	Нэр							
1.3	Хүйс /сонгох/						Эрэгтэй	Эмэгтэй
1.4	Төрсөн он,сар,өдөр							
1.5	Иргэний харьяалал							
1.6	Регистрийн дугаар							
1.7	И-мэйл хаяг:							
1.8	Гэрийн хаяг							
1.9	Холбоо барих утас:	1.	2.					
2 Боловсрол								
2.1	Төгссөн сургуулийн нэр	Хаана	Элссэнон	Төгссөнон	Эзэмшсэн мэргэжил	Диплом,Гэрчилгээнийдугаар		
2.2	Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхний	Дугаар		Авсан огноо	Дуусах огноо			
2.3	МХБ ТӨХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийн үнэмлэхний	Дугаар		Авсан огноо	Дуусах огноо			
3 Ажлын туршилага /Одоо эрхэлж буй ажлыг оролцуулан бичнэ/								
3	Хаана, ямар албан байгууллагад	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Ажлаас гарсан шалтгаан			
4 Гэр бүлийн байдал								
4	Таны юу болох	Овог нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар	Одоо эрхэлж буй ажил			

Монголын хөрөнгийн биржийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч “.....” компанийн үүсгэн байгуулагч/хувьцаа эзэмшигч/албан тушаалтан овогтой нь Монголын хөрөнгийн биржид ирүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ба цаашид Монгол Улсын хууль тогтоомж, үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох журам, заавар, гэрээтэй бүрэн танилцсан бөгөөд цаашид хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.

Батламжилсан:

/гарын үсэг/

БҮРТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН: _____ / Гарын үсэг/

БҮРТГЭЛТЭЙ ТАНИЛЦСАН: _____ /Компанийн захирал/

20 ... оны сарын өдөр

**Б) ГИШҮҮН КОМПАНИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙНАНКЕТ**

<i>Компанийн ерөнхий мэдээлэл</i>			
1	Компанийн нэр		
2	Байгуулагдсан огноо		
3	Регистрийн дугаар		
4	Компанийн харьяалал		
5	Үйл ажиллагааны чиглэл		
6	Хувьцаат капиталын дүн		
7	Гишүүн компани дахь эзэмшлийн мэдээлэл	Оруулсан хөрөнгийн үнийн дүн	Оруулсан хөрөнгийн хувь
8	Удирдлагын нэр		
9	Компанийн хаяг		
10	Вэб сайт		
11	И-мэйл хаяг		
12	Холбоо барих утас, факс		

МХБ ТӨХК-ийн гишүүн компани нь арилжааны системд холбогдохдоо дараах техникийн шаардлагыг хангасан байна:

Техникийн шаардлага

Millennium Exchange програмын Trader Interface –ийг суулгахад шаардлагатай техникийн шаардлага:

Холболтын шаардлага

- a. Програм хангамжийн түвшин дэхь VPN туннель
Холболтын зурвасын өргөн нь 2 Mbps болон түүнээс доошгүй байх шаардлагатай.
- b. Техник хангамжийн түвшин дэхь VPN туннель
Холболтын зурвасын өргөн нь 3 Mbps болон түүнээс доошгүй байх, IPSec дэмждэг сүлжээний төхөөрөмж байх шаардлагатай.
- c. Шууд холболт
Холболтын зурвасын өргөн нь 1 Mbps болон түүнээс доошгүй байх, IPSec дэмждэг сүлжээний төхөөрөмж болон холболтын шилэн кабел байх шаардлагатай.

Компьютерийн шаардлага

- Intel Dual Core болон түүнээс дээш загварын CPU
- 512 Мб болон түүнээс дээш хэмжээтэй шуурхай санах ой (трэйдэрийн профайлд хадгалах мэдээллийн хэмжээнээс шалтгаалж хувьсана)
- 120 Gb болон түүнээс дээш хэмжээтэй HDD
- 15 инч болон түүнээс дээш хэмжээтэй дэлгэц
- Стандарт гар болон хулгана
- Microsoft Windows XP болон түүнээс хойших үеийн Microsoft–ийн үйлдлийн систем
- Mozilla Firefox 5.0 болон түүнээс хойших хувилбарын интернет хөтөч
- Visual C++ redistribution package